Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний хяналтын улсын байцаагч, Оюун-Эрдэнэ Оргихбаяр

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | 1.1. Малын генетик нөөцийг ашиглах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | | | | | | |
| 1 | Малын генетик нөөцийг ашиглах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Шалгалт хийсэн объектын тоо | 0 | 1 | Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу Жаргалант суман үйл ажиллагаа явуулж буй Манхан чүг ХХК үржлийн нэгжид малын генетик нөөцийг ашиглах аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Манхан чүг ХХК үржлийн нэгж нь дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. "Малын генетик нөөцийн тухай" хууль, аймгийн Засаг даргын 2025 оны А/223 дугаар захирамжийн хүрээнд үржлийн мал сүрэгт хаврын үзлэг ангилалт, бог малын хээлтүүлэгч ялган төвлөрүүлэх технологит ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 21-нээс 05 дугаар сарын 04- ний хооронд сумдын Хөдөө аж ахуйн тасаг, мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжтэй хамтран хийж гүйцэтгэсэн.Үүнд: Баян-Өндөр, Жаргалант сумдын 50 малчин өрхийн 25.0 мянган толгой сүрэгт үзлэг ангилалт хийж, анги чанарыг тодорхойлон ажилласан. үхэр - 5214, хонь - | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 10812, ямаа – 8988. | | |
| 2 | Эрх бүхий албан тушаалтны шийдвэр болон иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу хийгдэх төлөвлөгөөт бус хяналт шалгалт | Зөрчил арилгалтын хувь | 0 | 100% | Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/07 дугаартай удирдамжийн дагуу цагаан сар, хүүхдийн баярын урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний хяналтын улсын байцаагч, ЭМГ-ын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нартай хамтарч 18 аж ахуйн нэгж, /түрээслэгч 72/, 2 иргэний үйл ажиллагаанд хийсэн. Шалгалтаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, шинжилгээний баримт бичиггүй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалах хөргөх, хөлдөөх тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй, температур хэмжигчгүй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэлтийн горимд температурын хяналт хийж, бүртгэл хөтлөөгүй, ажиллагсад эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй зэрэг 85 зөрчлийг илрүүлж газар дээр нь 70 зөрчил буюу 82%-ийг арилгуулж ажилласан. Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 3 аж ахуйн нэгжид 12 заалт бүхий хугацаатай албан шаардлага үйлдсэн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2.1. Хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр төрийн үйлчилгээг аж ахуйн нэгж, иргэдэд түгээх | | | | | | | |
| 3 | Иргэдэд чиглэсэн хүнсний чиглэлийн зөвлөмж, сэрэмжлүүлгийг олон нийтийн цахим сүлжээгээр түгээх | Зөвлөмж, сэрэмжлүүлгийн тоо 90 | 0 | Малчид, эрчимжсэн аж ахуй эрхлэгч 2 ААН, 40 иргэд, малчидад хүргэх | Хяналт шалгалттай холбоотойгоор хүнсний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор иргэдэд худалдан авч буй бараа бүтээгдэхүүнийхээ шошго, чанар, биет байдлыг сайтар шалгах, хэрэглэгчийн хяналтыг сайжруулах талаар орон нутгийн телевизээр 3 удаа мэдээлэл сэрэмжлүүлэг өгч, цахим хуудсанд 4 удаа нийтэлж түгээн ажиллалаа. Орхон аймгийн малчид, тариаланчдын зөвлөгөөн 2025.04.15-ны өдөр Жаргалант сумын Соёлын төвд 225 малчин, тариаланчдыг хамруулан зохион байгууллаа. Зөвлөгөөнд 12 байгууллагын 18 танилцуулга мэдээлэл хүргэж, 8 байгууллага нээлттэй хаалганы өдөрлөг хийн, үйл ажиллагаагаа | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сурталчлан ажиллалаа. Мөн энэ үеэр Мал эмнэлгийн эм бэлдмэлийн худалдаа, хүнсний ногооны үр бордооны худалдаа эрхлэгчид малчид тариаланчдад хүргэн ажилласан. Аймгийн Засаг даргын 2025 оны А/170 дугаар захирамжийн хүрээнд малчдад мал аж ахуйн салбарт шинээр батлагдан гарсан хуулийн танилцуулга болон малчдын эрх үүрэг, төр засгийн бодлого, шийдвэрийг хүргэх, хүн, мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлэх, цаг үеийн нөхцөл байдалтай танилцах зорилгоор 1, 3 дугаар саруудад Жаргалант сумын 2 чиглэлд 68 малчин өрхөөр орж төрийн үйлчилгээг хүргэж ажилласан. | | |
| 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 4 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Хууль, журмын дагуу хугацаанд хүргүүлсэн байна | 0 | Холбогдох хууль тогтоомжуудыг нэгжийн хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. | Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 2024 оны / орлогыг тооцох, дансны хуулга авч / ХАСХОМ-ийг 2025 оны 01 дүгээр сард гаргаж ашиг сонирхолын зөрчилгүй тухай мэдэгдэлийг баталгаажуулсан. Хуулийн хугацаанд шийдвэрлэж, биелэлтийг хангуулж ажилласан. Орхон аймгийн Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн анги, төр болон төрийн өмчит байгууллагуудын нөхөрлөлүүдийн дунд зохион байгуулагдсан Аварагч-2025 тэмцээнд ХХААГ-ын Хөдөө аж ахуйн алба, Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнтэй хамтран тэмцээнд амжилттай оролцсон. Аймгийн ИТХ-ын даргын нэрэмжит Төрийн байгууллагуудын волейболын аварга шалгаруулах тэмцээнд эрэгтэй, эмэгтэй баг бүрдүүлэн амжилттай оролцлоо. Тэмцээнд 37 байгууллагын 300 гаруй албан хаагчид оролцсон. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй цахим сургалтад хамрагдах. Монгол бичгийн сургалтад хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлэх. | 0 | Хууль тогтоомжийн мэдлэгээ сайжруулах, монгол бичгийн мэдлэгийн түвшингээ нэмэгдүүлэх. | 1. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй цахим сургалт 2. Монгол бичгийн сургалтад хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалт 3.Оффисын ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ойлголт" сэдэвт сургалт 4.“Анхны тусламж үзүүлэх” сэдэвт сургалт. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2 | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III хүрээнд босоо монгол бичигт суралцах, унших, бичих арга зүйг эзэмших | МУ-ын Засгийн газрын 2020 оны 03-р сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоол Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд монгол бичгийг бүрэн эзэмших суралцах | анхан шат | Монгол бичгээр унших, бичих, найруулах арга зүйд суралцсан байна | Засгийн 2020 оны 96 дугаар тогтоол "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хүрээнд 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах ажлын хүрээнд босоо суралцах, унших бичих арга зүй эзэмших сургалтанд хамрагдсан. Сургалтыг ерөнхий боловсролын 13-р сургуулийн Монгол бичгийн тэргүүлэх багшаар анхан болон дунд шатны | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтанд суралцаж зохих мэдлэгт суралцсан. | 11-р сар, 12-р сар | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний хяналтын улсын байцаагч, Оюун-Эрдэнэ Оргихбаяр /............................................................./
Огноо: .........................